



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 1115

Номгон

Агаарын бохирдлын эх үүсвэрийн
нэгдсэн тоо бүртгэлийг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ын 3.1, 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг 2026 оны 01 дүгээр сарын 09 -ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийг нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Бат-Өлзий Байгаль орчны газрын дарга

Гишүүд:

С.Рэнцэндагва Татварын газрын дарга

С.Батцэрэн Авто тээврийн төвийн дарга

Б.Мягмарсүрэн Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Дэд хурандаа

Д.Батзаяа Цагдаагийн газрын дэд дарга, Цагдаагийн дэд хурандаа

Д.Балжмаа Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Ц.Пүрэвсүрэн Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Б.Сэвжиддулам Байгаль орчны газрын мэргэжилтэн

Сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, Байгаль хамгаалагч нар

Нарийн бичгийн дарга:

Ч.Оюунчимэг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

2.Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллогыг журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, тооллогын дүнг нэгтгэн боловсруулж 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлж, холбогдох баримтыг Төрийн архивын тасагт шилжүүлж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр) -т даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

